

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО БА УЛАМЖЛАЛТ БУС АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ: МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ШИНЭ ОРЧИН

*Ч.Батцэцэг**

Орчин үед дэлхийн хүн амын хэрэгцээ асар хурдацтай өсөн нэмэгдэхийн хирээр шинжлэх ухаан-технологи үсрэнгүй хөгжиж, юмс үзэгдэл маш түргэн хувьсан өөрчлөгдөх боллоо. Үүнийг дагаад аливаа улс орны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын талаархи онол, агуулга, ойлголт, сэтгэлгээ, ухамсар ч мөн ихээхэн өөрчлөгдөж байна.

Ер нь аюулгүй байдлын хэм хэмжүүр гэж юу вэ? Аюулгүй байдал нь хүн төрөлхтөний хүсэл эрмэлзлэлийн нэн чухал үндсэн зорилгын нэг юм. Хувь хүн, нийгэм, улс орон төдийгүй дэлхий нийтийг цогцоор нь аюулгүй байдлаас салгахын аргагүй билээ. Улсын аюулгүй байдал, олон улсын аюулгүй байдал болон дэлхийн аюулгүй байдал нь түүнийг сахин хамгаалах үзэл баримтлалаас эхэлдэг.

Нэг улсын хувьд авч үзэхүл, аюулгүй байдал нь тухайн улсын хувь заяа, улс орныг удирдан жолоодох үндэс суурь болно. Улс орны түүх, соёл, нутаг дэвсгэрийн байдал, түүнийг удирдан жолоодох арга барил харилцан адилгүй байхаас хамааран улсын аюулгүй байдлын дотоод асуудал, ойлголт, сэтгэлгээ өөр өөр байх агаад олон улсын тогтолцоо хийгээд тухайн улсын байр суурь, хүчин чадлын бодит байдал харилцан адилгүйгээс тэр улсын аюулгүй байдлын зорилго, шаардлага мөн өөр өөрийн гэсэн онцлогтой байдаг аж. Гагцхүү аль ч улсын төр, засгийн газар нь бүгд улс орныхоо аюулгүй байдлыг сахин хамгаалах нэн тэргүүний чухал үүрэг хариуцлагыг зайлшгүй хүлээдэг байна. Улсын аюулгүй байдлын язгуур үндэс нь улсын бие даасан бүрэн эрхийг хамгаалах явдал юм. Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, өөрөө оршин тогтнох болон хөгжих эрхийг тодорхойлж, түүнийг сахин хамгаалах нь улсын аюулгүй байдлын хамгийн дээд хэмжүүр бөлгөө. Улсын аюулгүй байдлыг сахин хамгаалахын тулд улс орны онцлог, цаг хугацаанаас хамаараад магадгүй өөр өөр үүрэг зорилго, хүсэл эрмэлзлэлтэй байдаг боловч улсынхаа тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэстний эв нэгдэл, улс төрийн тууштай бодлого, нийгмийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжил, цэрэг зэвсгийн хүчирхэг байдал зэрэг нь бүгд тухайн улсын аюулгүй байдлыг сахин хамгаалах агуулга, зорилгод багтдаг.

Иймд аливаа улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь төрийн бодлогын илэрхийлэл болж урт хугацаанд үргэлжлэхийн сацуу түүнд дэлхий дахины өөрчлөлтийн явц, нөхцөл байдалд тохируулсан тодотгол хийж, дотоод гадаад бодлогын мөн чанарыг нэмэгдүүлэн сайжруулах, төр, нийгэм, ард иргэдийн хүсэл эрмэлзлэлийг нэгтгэсэн тодорхойлогч хүчин байх ёстой.

Олон улсын нөхцөл байдал, түүхэн туршлагын талаархи хүмүүсийн ухамсар, сэтгэлгээ хувьсан өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор олон улсын

* Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

уламжлалт аюулгүй байдал мөн тасралтгүй өөрчлөгдөн хувирч байгаа тухай дээр дурьдсан. Үүнийг хүйтэн дайн төгсгөл болсноор тухайн үед олон улсын харилцааны гол тавцанд ноёрхож байсан цэргийн үйл ажиллагаа, жанжлах улс төрийн бодлого өөрчлөгдөж, улс орнууд хоорондоо эдийн засгийн хүчин чадлаараа өрсөлдөж буйгаар тайлбарлаж болох юм.

Аливаа улс орны үндэсний аюулгүй байдал нь гадаад, дотоод нөхцөл гэсэн хоёр хүчин зүйлээс үүдэн гардаг зүй тогтолтой. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухайд хөрш орнуудын хүчин зүйлээс ихээхэн хамааралтай шинжтэй уламжлалт аюул заналхийлэлд өртөмтгий явж ирсэн.¹ 90-ээд оноос Монгол Улс нь дэлхий дахины өөрчлөлтэй холбогдуулан улс үндэстнийхээ аюулгүй байдлыг тал бүрээс нягтлах, асуудлыг бие даасан бодлогоор шийдвэрлэх шаардлагатай тулгарсан юм. Улс үндэстнийхээ аюулгүй байдлаа хангахын тулд 1994 онд “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг Монгол Улсын Их Хурлаар батлав. Үндэсний аюулгүй байдлыг энэ баримт бичигт тодорхойлохдоо, Монгол Улсын үндэсний язгуур эрх ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдаж байхыг хэлнэ хэмээжээ. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын бүтцэд: 1. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал, 2. нийгэм төрийн аюулгүй байдал, 3. иргэдийн эрх чөлөө, эрх чөлөөний аюулгүй байдал, 4. эдийн засгийн аюулгүй байдал, 5. шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал, 6. мэдээллийн аюулгүй байдал, 7. монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, 8. хүн ам, удмын сангийн аюулгүй байдал, 9. экологийн аюулгүй байдал² эдгээр зүйлийг багтаасан байна.

XXI зуунд дэлхийн эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн үсрэнгүй хөгжил, улс орнуудын соёл иргэншлийн өвөрмөц байдал зэргээс хамааран аливаа улс орны үндэсний аюулгүй байдал, хөгжлийн явц ямагт харилцан уялдаатай байж, тухайн асуудлыг шийдвэрлэх болжээ. Иймд Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хүн төрөлхтний нийтлэг ашиг сонирхолтой уялдуулан нийцүүлэх бодлого хэрэгжүүлэх нь зайлшгүй болж ирэв. Монгол Улс нь ОХУ, БНХАУ гэсэн хоёр их гүрэнтэй хил залгаа оршдогийн тухайд хоёр хөрштэйгээ тэнцвэртэй найрсаг харилцаж, сайн хөршийн ёсоор хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж, харилцан итгэлцэх, харилцан ойлголцлыг бэхжүүлэх үндсэн дээр сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг бүхий л салбарт амжилттай хөгжүүлж байна. Хөрш улсуудын маань олон улсын тавцанд эзлэх байр суурь, нөлөө түргэн өөрчлөгдөхийн хирээр эргэн тойрны геополитик болон гео-эдийн засгийн орчин хувьсан өөрчлөгдсөөр байна. Манай хөрш хоёул цөмийн зэвсэгтэй, хоёул эдийн засгийн асар их хүчин чадалтай, хоёр том зах зээлтэй гэх зэрэг давуу тал олон боловч манай улстай залгаа хил орчмын бүс нутаг нь эдийн засгийн хөгжлөөр харьцангуй доогуур, ДОХ-ын халдварт өвчтөний тоогоор харьцангуй дээгүүрт ордог гэх мэт сул тал ихтэй.

Сүүлийн үед Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны эрс өөрчлөлт, дотоодын нөхцөл байдал, гадаад хүчин зүйлээс үүдэлтэй уламжлалт бус аюулын асуудал улам бүр нэмэгдэх хандлагатай болж байна.

Тухайлбал, гадаад, дотоодын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн нэмэгдэх, хил дамнасан хулгай, дээрэм, гэмт хэрэг элдэв зөрчил ихээхэн гарч, цөмийн болон химийн хортой бодис тээвэрлэх, хууль бус наймаа арилжаа эрхлэх, хүн худалдаалах, хар тамхи мансууруулах бодисыг зөөвөрлөх, дамжин өнгөрүүлэх, хугацаа хэтэрсэн баталгаагүй хүнсний зүйлийг авчирч худалдаалах, байгаль экологийн унаган төрхийг сүйтгэх, ховор ан амтан устгах гэх мэт элдэв явдал гарах болсноор манай улсын үндэсний аюулгүй байдлын хүчин зүйлд сөргөөр нөлөөлөх, зарим тохиолдолд бүр ноцтой хохирол учруулах хэмжээнд хүрч байна.

Монгол Улс хөрш БНХАУ-тай харилцан, хамтын ажиллагаа явуулж байгаа өнөөгийн гадаад орчны таатай шинэ нөхцөл байдалд үндэсний аюулгүй байдлын бодлого болон уламжлалт бус аюулгүй байдлын асуудал, түүний үр дагаврыг хоёр орны жишээн дээр тус тус авч үзье.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын асуудал урд хөрштэй хэрхэн холбогдож байгаа талаар түүх сөхөж үзэхүл, “хятадын аюул” хэмээх үзэл монголчуудад нэн эртнээс бүр Хүннүгийн үеэс хятадууд нүүдэлчидтэй худалдаа хийхийг хориглож байсан, монголчууд хятадын бичиг соёлыг дагахгүй гэж тэмцэлдэж байсан тэр цагаас тогтож, хятадын нөлөөнд орох вий гэсэн болгоомжлол мөн тэр үеэс бий болсон хэмээн зарим эрдэмтэн судлаачид үздэг. Улмаар Дундад Иргэн Улсын үед Монголыг Хятадын бүрэлдэхүүнд оруулах саналыг тавьж байсан, 3 улсын гэрээгээр Монголыг Хятадын бүрэлдэхүүн хэсэг гэж тунхаглаж байсан, Хятадын удирдагч Мао Зэдун 50-60-аад онд “соёлын хувьсгал”-ынхаа үеэр Монголыг Хятадын бүрэлдэхүүн хэсэг хэмээн зарлаж байсан зэрэг нь Монголын үндэсний аюулгүй байдлын асуудалтай шууд холбогдоно. Нөгөөтэйгүүр Монголын эзэнт гүрэн бусад улс орнуудыг эзэлж, хүчирхэг явсан баатарлаг түүхийн бахархал хийгээд хятадын нэг хэсэг хэзээ ч байгаагүй гэсэн монголчуудын үзэл, Монголд ирж суурьшин худалдаа наймаа эрхэлсэн мөнгө хүүлэгч хятад иргэдэд (华侨 hua qiao хятад цагаач гэсэн үг – монгол дуудлагаар хужаа хэмээн нэрлэх болсон - Ч.Б) таагүй байсан зэрэг нь монголчуудын ухамсар сэтгэлгээ, ой тойнд нэвт шингэж, хятадуудад дургүй байх хандлага зарим монголчуудад бүр эртнээс уламжлан амь бөхтэй оршсоор өдгөөг хүрсэн гэж хэлж болно.

Харин Хятадын тал бүр эртнээс “Монгол нь манай улсын салшгүй хэсэг мөн”, “монголчууд бол зэрлэг бүдүүлэг нүүдэлчид” гэдэг үзлийг ард түмнийхээ тархинд бүр багаас нь суулгаж өгснөөр тайлбарлагдана. Энэ үзэл санаа орчин үед ч уламжлагдан үргэлжилж БНХАУ-ын дунд сургуулийн түүхийн сурах бичигт Монгол нь Хятадын бүрэлдэхүүн хэсэг байсан бөгөөд дэлхийн II дайны дараа сая тусгаарласан, Чингис, Хубилай бол манай хятад үндэстний баатар хэмээн бичиж сургаж ирснээс бага, дунд, ахлах сургуулиар дамжсан хятадын ард түмэн Монгол Улсын тухайд ойлголт ямар байх нь тодорхой. Дэлхий дахинд даяарчлал, ардчилал хөгжиж, үндэсний ухамсар сэргэж буй өнөөгийн шинэ орчинд ч Хятадын хэвлэл, түүхийн ном, сурах бичигт Монгол нь Хятадын салшгүй хэсэг гэсэн уламжлалт бодлогыг баримтлан бичсээр байна. Үүнийг Монголын талаас эрдэмтэн судлаачид

эсэргүүцэн няцаалт өгч хариу шаарддаг боловч Хятадын тал үүнийг Хятад улсын албан ёсны байр суурь биш хэмээдэг, иймэрхүү зүйл удаа дараа хэвлэгдсээр байгаа явдлыг хэрхэн тайлбарлах вэ?

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хөндсөн, түүнд харшилсан болон Монгол Улсын нэр хүндийг гутаахад чиглэсэн аливаа явууллагад цаг тухайд нь үндэслэл бүхий няцаалт өгч, шаардлагатай гэж үзвэл төрийн бодлого, үйл ажиллагаандаа зохих ёсоор тусгаж байх тухай заасан. Тусгаар тогтносон, бүрэн эрхт Монгол Улс нь НҮБ-ын гишүүн орон, дэлхийн улс орны түүхийг бүтээлцэхэд оруулсан хувь нэмрээрээ алдартай, нүүдэлчдийн соёл иргэншил, өв уламжлалыг хадгалж үлдсэн, уул уурхай байгалийн баялгаараа дэлхийн улс орнуудын анхаарлыг татсан, ардчилсан хүмүүнлэг нийгмийг цогцлуулж буй улсын нэг юм. Өнөөдөр дэлхий дээр Монгол Улс, БНХАУ нь хоорондоо газар нутгийн маргаан, хилийн будлиангүй орны тоонд зүй ёсоор ордог.

90-ээд оноос Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн ба БНХАУ нь 1978 оноос нээлттэй бодлого явуулж, өөрчлөлт шинэчлэлийн их бүтээн байгуулалтыг эхлүүлсэн юм. Ийнхүү 90-ээд оноос манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа салбар бүрт өргөжиж, хоёр орны жирийн ард иргэд ч хоорондоо урьд хожид байгаагүй ихээр харилцах болов. Ялангуяа Монгол Улс нь 1994 онд БНХАУ-тай харилцах зарчмын шинэ хандлагад тулгуурласан “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” байгуулж, сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг шинэ шатанд гаргаснаар хоёр улс харилцан ашигтай хамтын ажиллагааг улс төр, эдийн засаг, худалдаа-бизнес, боловсрол соёл, шинжлэх ухаан, хүмүүнлэг, байгаль экологи, батлан хамгаалах зэрэг бүхий л салбарт хөгжүүлж ирэв. 2000 оноос хойш Хятадын эдийн засгийн үсрэнгүй хөгжил манай улсын эдийн засгийн байдалд, ард түмний аж амьдралд улам ихээр нөлөөлөх болсныг тэмдэглэх нь зүйтэй.

XXI зуун гарсаар дэлхий даяар шинжлэх ухаан техник маш хурдацтай хөгжихийн сацуу хүн амын хэрэгцээ асар ихээр өсөн нэмэгдэж, үүнтэй уялдаад дэлхийн дулаарал, хэзээ ч эргэн нөхөгддөггүй газрын хэвлийн баялгийн нөөц хэмжээ шавхагдан дундарч эхлэв. Манайд улс үндэстнийхээ хөгжил цэцэглэлтийг тодорхойлох төдийгүй, бүс нутгийн хэрэгцээг хангахуйц дэлхийн хэмжээний бүлэг томоохон орд газрын нөөц тогтоогдож, хөрөнгө оруулалт хийгдэж, ашиглалтанд оруулах хэрэгжүүлэх шатандаа явж байгаагийн зэрэгцээ төрөл бүрийн ашигт малтмалын олон арван орд аж ахуйн эргэлтэнд орох нөхцөл бүрдээд байна. Эдгээр орд илэрснээр Монгол Улс дэлхийн улс орнуудын анхааралд өртөж, ялангуяа ОХУ, БНХАУ, АНУ, Канад, Япон, Солонгосын хөрөнгө оруулагчдыг ихээр татах болсон. Эдгээр хөрөнгө оруулагчид өөрсдийн эрх ашгийн төлөө манай шийдвэр гаргагч эрх мэдэлтнүүдийг хооронд нь өрсөлдүүлж улмаар тэдний байр суурийг ашиглан лоббидож, хооронд нь талцуулах, тухайн эрх мэдэлтний ард чухам ямар улс байна, хэний эрх ашгийг хамгаалж байна вэ гэсэн хардлагыг ард түмэнд

төрүүлж, одоогоор зарим нэг асуудал шийдвэрлэгдэж байгаа ч маргаан үргэлжилсэн хэвээр байна. Уг нь Монгол Улсын Үндсэн хуульд байгалийн баялаг бол ард түмний өмч хэмээн заасан байдаг.

Манай хөрш Хятад улс эрчимтэй хөгжихийн хирээр зэс, эрчим хүчний дутагдалд орж, байгалийн баялаг, ашигт малтмалын түүхий эд, зэс, ган төмөр, нүүрсний 30-аад хувийг далайн чанадаас тээвэрлэж байгаа бөгөөд энэ нь хоёр орон бие биеэ нөхөн хөгжих сайхан боломжийг нээж өгч байгаа юм. 2007 оны байдлаар Хятад манай улсын уул уурхай салбарын 60%-д хөрөнгө оруулалт хийж, хамтарсан томоохон төслүүдийг хэрэгжүүлжээ. Гэвч сүүлийн жилүүдэд Монгол Улсад оруулж буй гадаадын хөрөнгө оруулалтын нийт хөрөнгийн 60% нь ийнхүү уул уурхайн олборлох салбарт орж ирсэн нь хөрөнгө оруулалтын бүтэц хэт өрөөсгөл байгааг харуулж байгаагаас гадна элдвийн зөрчлийг дагуулах болжээ. Манай улсын ашигт малтмалын талаархи хууль тогтоомжийн цоорхойгоос үүдэн гарсан ашигт малтмал эрж хайх, олборлох, ашиглах эрхийг шууд ба шууд бусаар эзэмших, хөрөнгө оруулагч гадаад дотоодын компаниудын үйл ажиллагаа, түүнд зуучлагч нарын ашиг сонирхлоос болсон зөрчил, хүндрэл гарсаар байна. Ялангуяа уул уурхай, ашигт малтмалыг Хятадын жижиг компаниуд, хувь хүмүүс хууль бусаар олборлох явдал ихэссэнтэй холбоотойгоор түүнд ашиглагддаг цианит натри, мөнгөн ус, метилийн спирт гэх зэрэг химийн бодисыг нууцаар тээвэрлэн хил нэвтрүүлж, хаа сайгүй ашиглаж, нутаг орон, ард иргэдийг хордуулж байлаа. Тухайлбал: Дархан-Уул аймгийн Хонгор сумын ард иргэд хууль бусаар алт угааж байсан хятад иргэдийн цианит, мөнгөн усанд хордож, хор уршиг нь одоо болтол үргэлжилсээр байна. Тавантолгойн нүүрсний уурхайгаас хүнд даацын ачааны тэргээр Хятад руу олон жилийн турш нүүрс тээвэрлэснээс онгон байгалийн хөрсийг эвдэж, дур зоргоороо олон салаа зам гаргаж, тухайн нутаг орныг тоосоор дарж, байгалийн нөхөн сэргээлт хийгээгүйн улмаас өргөн уудам нутагт мал аж ахуй, хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэх ямар ч боломжгүй болгожээ. Манай бусад олон аймаг сум, орон нутаг, бэлчээр тариалан уурхайн талбайн олборлолтонд өртөж, байгаль экологийн тэнцвэртэй байдал алдагдан гол горхи ширгэж, цөлжилт, цэвэр усны нөөцийн асуудлыг хурцатгахын зэрэгцээ уул уурхайн болон мал аж ахуйн түүхий эдийн нөөцийг шууд Хятадад гаргаж байгаа явдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болохуйц хүчин зүйлийн нэг юм.

Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын үндсэн зорилго нь гадаадын хөрөнгө оруулагчдад татварын болон бусад хөнгөлөлт, урамшуулал олгох, тэдгээрийн хөрөнгө өмчлөх эрх, хөрөнгө оруулалтыг хамгаалах хууль зүйн баталгааг хэрэгжүүлэх, хүнд суртлыг арилгахад оршдог. Стратегийн ач холбогдол бүхий байгалийн баялаг, үйлдвэрлэлийг ашиглахтай холбоотой хөрөнгө оруулагчдад улс орны үндэсний аюулгүй байдалтай холбоотой тодорхой нөхцлүүдийг дагаж мөрдөх шаардлага тавьдаг боловч түүнийг тэр бүр хэрэгжүүлдэггүй, дагаж мөрдөх явдал туйлын хангалтгүй байсаар байна. Харин ч Хятадын тал Монголд ашигт малтмал

олборлохдоо өөрсдөө зам гаргаж байгаа мэтээр, байгалийн нөхөн сэргээлт хийгээгүй компаниудаа Хятадаас албан ёсоор хөрөнгө оруулж буй компани биш хууль бусаар орж ирсэн жижиг компаниуд олборлолт хийгээд гарсан гэх зэргээр ярьж бичих болжээ. Энэ бүхэн хэзээнээсээ хятадуудад таагүй ханддаг зарим монголчуудын дургүйцлийг төрүүлж, хятадын эсрэг үзлийг улам өдөөх болсон нь манай улсад ажиллаж буй хятадын хөрөнгө оруулагчид, ажилчдын хариуцлагагүй байдал, монголын талын хуулийг гууль болгогч зарим этгээдүүдтэй шууд холбогдоно. Иймэрхүү байдал газар авбал хоёр улсын харилцаанд сэв суулгах улмаар хоёр орны жирийн ард иргэдийн найрамдал, нөхөрлөлд нөлөөлөх магадлалтай.

Экологийн аюулгүй байдлын тухайд байгаль, цаг уурын өөрчлөлт болон байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах бодлогын харьцаа алдагдснаас хүний амьдрах орчин, эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх нөхцөл байдлыг хангагдсан байдлыг хэлнэ гэж заасан. Манай улс, Хятад улстай байгаль экологийн аюулгүй байдлын асуудалтай гарцаагүй шууд холбогдох зүйл бол цөлжилтийн асуудал, мөн түүнчлэн уул уурхайн олборлолтоос үүдсэн хөрсний эвдрэл, хятад иргэд манай улсын байгалийн нөөц баялаг эмийн ургамал, ан амьтан, шувууг олноор нь устгаж урагшаа хил давуулж байгаа явдал юм. Дэлхийн цаг уурын өөрчлөлт Зүүн хойд Азийн бүс нутгийн орнуудад бүгдэд нь хамааралтай болж, олон нийтлэг асуудал тулгарч байгаагийн дотор цөлжилт, элс шороон шуурга, шар шорооны нүүдэл багтаж байна. Жил бүр Монголын хээр тал, говиос их хэмжээний шар шороо босч Хятад, Солонгос, Япон, Америкийн баруун эрэгт хүрч, хөнөөл учруулдаг болсоор багагүй хугацааг ардаа орхижээ. Ялангуяа Монгол, Хятад хоёр улсад цөлжилтөөс улбаалсан шороон шуурга шуурах нь олширч, хүн байгальд ихээхэн аюул гамшиг, алдагдал хохирол учруулж байна. Энэ асуудлаар хоёр талын эрдэмтэн судлаачид хамтран ажиллаж төсөл боловсруулж, хурал симпозиум хийхийн зэрэгцээ манай улсын санаачилгаар Монгол, Хятад, Япон, Солонгос зэрэг улс орон шар шороон шуурганы аюулыг багасгах талаар хамтын хүчин чармайлт тавьж, ЗХА-ийн орнуудын байгаль экологийн салбарын холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдийн ажлын уулзалт зохион байгуулах зэрэг нааштай алхмууд хийгдсээр байна. Мөн зарим ан амьтан, шувууг тухайлбал цагаан зээр, шонхор шувууг 2 жилд агнахыг хориглосон тогтоолыг 2009 онд Монгол Улсын ерөнхий сайд С.Батболд гаргажээ.

90-ээд оноос хойш манай улсын улс төр нийгэм, эдийн засгийн харилцаанд өөрчлөлт гарснаар хүн амын шилжих хөдөлгөөн маш эрчимжиж байна. Орчин үеийн олон улсын ажиллах хүчний шилжилтийг (миграци) дотор нь 5 хэсэгт хуваадаг байна. Үүнд: нэгд, хөгжиж байгаа орноос өндөр хөгжилтэй орнууд руу шилжих; хоёрт, өндөр хөгжилтэй орнуудын хоорондын шилжилт; гуравт, хөгжиж байгаа орнуудын хоорондын шилжилт; дөрөвт, хуучин социалист орнуудын шилжих хөдөлгөөн; тавд, аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудаас нарийн мэргэжлийн чадвартай мэргэжилтэн, ажилтнууд хөгжиж байгаа орнууд руу шилжиж

байгаа хөдөлгөөн багтана.³ Монгол Улсын хувьд дээрхи ангиллын дөрөвдүгээрт орж байна. Шилжих хөдөлгөөн нь газар зүйн талаасаа гадаад, дотоод гэж хуваагддаг бөгөөд дотоод нь улс дотроо буюу хот, хөдөөгийн хоорондын шилжих хөдөлгөөн, гадаад нь бүс нутаг болон тив хоорондын гэж хуваагддаг ажээ. Манай улсад дотоод, гадаадын шилжих хөдөлгөөн аль аль нь маш эрчимтэй явагдсаар байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд Монгол Улсын хүн амын ажилгүйдлийн тоо эрс нэмэгдэж, хот руу шилжин суурьших хөдөлгөөн эрчимтэй явагдснаас орон нутгийн хүн ам цөөрч, хөдөө нутаг эзгүйрэх хандлагатай байна.

Улс орон бүр шилжих хөдөлгөөний бодлого явуулахдаа өөрийн үзэл бодол, чиг хандлагыг баримталдаг боловч тухайлбал гадаадын ажиллах хүчний шилжих хөдөлгөөний үйл ажиллагааг зохицуулахын тулд олон улсын байгууллагаар батлагдсан нэгдсэн хэм хэмжээ, стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг. Хэдийгээр Монгол Улсын хөгжлийн хандлагаас гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч авах шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байгаа боловч манай улс гадаадад ажиллах хүчний асуудлыг зөвхөн сонгуулийн өмнө сурталчилгаанд ашиглах хэлбэрээр аль болох улс хооронд зуучилж мөнгө олох ашиг сонирхолын дагуу явуулж, нөхөн үржихүйн насны ид хаваа гайхуулж яваа залуусыг олноор нь гаргаж буй явдал улс үндэстэнд маш хортой үйлдэл болж байна. Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль, мөн Засгийн газрын 1994 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Ажиллах хүч гадаад оронд гаргах, гадаад орноос авах журам”, Хөдөлмөрийн сайдын 1995 оны 201 тоот тушаалаар баталсан “Монгол Улсын иргэдэд гадаадад хөдөлмөр эрхлэхэд нь зуучлах үйлчилгээ явуулах эрхийн зөвшөөрөл олгох журам”-ын дагуу зохицуулах болсон. 2001 онд “Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль”-ийг УИХ-аар баталжээ.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-аас маш олон хүн гадагшаа цагаачилж байгаагийн тод жишээг дурьдвал АНУ, ОХУ болон бусад оронд жил бүр 100,0 мянган хятад иргэд хууль бусаар цагаачилж байгаа тухай гадаадын хэвлэлд бичсээр байна. Монгол Улс, ОХУ-тай хил залгаа БНХАУ-ын хил орчмын бүс нутгийг хөгжүүлэх төслийн хүрээнд хүн амын нягтаршил, суурьшил нэмэгдэхийн хирээр ажилгүйчүүдийн тоо ихсэж, хятадын ажилгүйчүүдийн гадагшлах урсгал ОХУ-ын Алс Дорнодын холбооны тойрог болон хил орчмын бүс нутгууд шилжих нөхцлийг бүрдүүлснээр, хууль бусаар шилжин ирэгсдийн тоог нэмэгдүүлж “хятадын аюулыг” бий болгож байна. Тухайлбал: ОХУ-ын бүх нийтийн хүн амын 2002 оны тооллогоор Оросын нутаг дэвсгэрт ойролцоогоор 35 мянган хятад иргэн зөвхөн байнгын оршин суух хаягаар бүртгэгджээ.⁴ Гэвч Оросын нутаг дэвсгэрт албан бусаар амьдарч ажиллаж байгаа хятад иргэдийн тоо тодорхой бус хэдэн зуун мянгаас саяар хүртэл тоологдож байгааг албан ёсоор хариуцсан тухайн

байгууллагууд хариуцлагатай ажиллахыг сануулсан мэдээ баримт гарсаар байна. ОХУ дахь хятадын ажиллах хүчний урсгалыг хагас саяас илүүгүй байхаар зохицуулах талаар ч яригдах болжээ. Хятадын үндэсний статистикийн тооцоогоор, Хятадын Зүүн хойд 3 мужид л гэхэд жил бүр 10 сая гаруй хүн ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй байна. Иймд Хятадын тал ОХУ-ын Алс Дорнод руу жилдээ 200-300 мянган хүн явуулахад бэлэн байгаа ажээ.⁵ Хятадаас шилжин ирэгсдийн урсгалын дийлэнхи нь ОХУ-ын Алс Дорнодын холбооны тойргоор дамжин Зүүн Өмнөд Ази болон АНУ, Канад, Австрали руу чиглэдэг байна.

Монгол Улсын Гадаадын иргэний эрхзүйн байдлын тухай хуулиар цагаачид манай хүн амын нэг хувиас хэтрэх ёсгүй байдаг. Тэр дундаа нэг улсын иргэн дээрх нэг хувийн 0,33 хувиас ихгүй байхаар хуульчилсан. Манай улсын хэвлэл мэдээлэл, холбогдох байгууллагын газраас энэ асуудлаар гарч буй тоо баримт бас хоорондоо маш их зөрүүтэй учраас нэгдсэн тодорхой тоо баримт, байгууллага, албан газар хоорондын уялдаа холбоо үгүйлэгдэж байна. 2009 оны 9 дүгээр сарын байдлаар 101 орны 35 мянган хүн Монголд ажиллаж, амьдарч байна гэж мэдээлсэн боловч чухам аль орны хүн гэдэг тоог нарийвчлан гаргаагүй байна. Гэхдээ Хятадаас жилдээ 25 мянга гаруй ажилчин орж ирдэг⁶ гэсэн албан бус мэдээлэл бий. “Манай улсын барилгын салбарт ажиллах монгол хүн цөөн учраас хятад ажилчдыг бүрмөсөн гаргахгүй цөөрүүлэх бодлого баримтлана”⁷ гэж Монголын хүний нөөцийн институтын мэдэгдэл гарсан байна. Энэ нь магадгүй нарийн мэргэжлийн инженер техникийн ажилтныг гадаадаас авч болох боловч манай улс өөрсдийн мэргэжлийн ажиллах хүчийг бэлтгэж сургах шаардлага гарцаагүй байгаагийн нэг илрэл юм. Манайд ирж буй хятад иргэдийн олонхи нь барилга, уул уурхайн салбарт Улаанбаатар, Орхон, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Дорноговь аймагт зөвшөөрөлтэй ажилладаг бол хэдэн мянган хүн хууль бусаар хөдөө орон нутагт, эзгүй газар очиж суурьшин амьдарч байгаагийн ихэнхи нь бичиг үсэггүй, эрүүл мэндээр сул дорой, ажил мэргэжлийн үнэмлэхгүй тариачид олноороо ирж байна. Ийнхүү хөдөөнөөс хот руу шилжигсдийн тоо өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж, тэдгээрийн орон зайг хятадууд эзэлж буйгаас байгаль экологитой зохисгүй харьцаж, эмийн ургамал түүх, ховор ан амьтан, шувуу, загасыг зүй бусаар агнаж устган хилийн боомтуудаар гаргах оролдлого хийх боллоо. Нөгөө талаас тэдгээр хууль бусаар орж ирэгсэд Монгол Улсад оршин тогтнохын тулд монгол охидуудтай албан бусаар гэр бүлийн харьцаанд орж, гэр орноор нь орогнож, үр хүүхэдтэй болгож, нутаг буцаж байгаа явдал монголчуудын удмын сангаа цэвэр ариун байдлаар хадгалахад сэв суулгаж байна гэж үзэх талтай. Монгол Улсад оршин суух гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн тоо, тэдний зорчин явах журмыг хуульчлан тогтоож, хяналт тавих, Монгол Улсад хууль бусаар оршин суух явдлыг гаргуулахгүй байх хяналтын тогтолцоотой болох, гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс Монголд олноороо суурьших, үндэсний мэргэжилтэй боловсон хүчин олноороо гадаадад цагаачлах тухай Үндэсний аюулгүй

байдалд тусгасан хэдий ч амьдралд хэрэгжихгүй, холбогдох байгууллагууд шалгалт хийж хууль бусаар орж ирсэн хятад иргэд, ажилчдыг олноор нь нутаг буцааж байгаа боловч энэ байдал давтагдсан хэвээр байна. Тухайлбал: 2009 оны 10 дугаар сарын байдлаар 2365 хятад иргэдийг албадан нутаг буцаажээ.

Монгол Улсад Хятадын хөрөнгө оруулалтай пүүс компаниуд бүртгүүлэн⁸ эдийн засаг, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа боловч хоёр орны засгийн газрын зөвшөөрлийн дагуу ажиллаж буй нь харьцангуй цөөн, дийлэнхи нь хууль бусаар ажиллаж байгаагаас элдэв бэрхшээлтэй тулгарч, олон сөрөг үр дагавар гаргаж байгаа нь “хятадын эсрэг үзэл”-ийн хүчин зүйлийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байгаа юм.

Монгол Улс, БНХАУ-тай албан ёсоор эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаагаа хөгжүүлж, хоёр орны гэрээ хэлэлцээрийн дагуу үйл ажиллагаа явуулдаг. Монгол, Хятад нь хоёулаа ДХБ-ын гишүүн улс юм. Гэхдээ хоёр улсын хооронд төлбөр тооцооны маргаантай асуудал үүсч, ДХБ-ын дүрэм журмыг баримтлахгүй түүнийг хөсөрдүүлэх тохиолдол гарсаар байна.

Монголын нэртэй пүүс компаниуд, хятадтай хамтарсан томоохон аж ахуйн нэгжүүд харилцан үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ жирийн ард иргэд, жижиг аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчид Хятадаас тоног төхөөрөмж, барилгын материал, эд бараа, хүнс, жимс ногоо, сүү, гахай, тахианы мах, өндөг, будаа, гурил, ундаа ус гэх мэт томоос жижиг сажиг хүртэлх ойр зуурын ахуйн хэрэгцээний бүхий л зүйлийг зөөвөрлөн авчирч зах зээлээр борлуулан амь зууж, ахуй байдлаа авч явж байна. Хэдийгээр энэ нь манай ядарсан ард иргэдийн аж амьдралд нэмэр болдог ч бас нэрмээс болдог тал бий. Тэдгээрийн ихэнхи нь зөвхөн Хятадын хилийн боомт хот Эрээнээс (Эрлян) өөрсдийн боломж, мөнгө төгрөгийн бололцооны хэр хэмжээнд тохируулан аль болох хямд төсөр, чанар муутай, өттэй, хогтой, муудсан, баталгаагүй, шинжилгээгүй, хуурамч эд барааг хятад түншүүдээсээ бөөнөөр авч, зөөвөрлөн борлуулдаг нь монголчуудын хэрэгцээг хангах бус, харин хүнсний аюулгүй байдлын баталгааг алдагдуулан, ард иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж ард иргэдээ санаатай болон санамсаргүй хордуулж байгаа хэрэг болон хувирч байна. Монгол Улсад худалдаа наймаа, жижиг бизнес эрхэлж байгаа хятадууд зөвшөөрөлгүй ажиллаж, улсад төлөх татвараас зайлсхийж, монгол хүний нэр дээр ажиллах гэрээ, лиценз авч байна. Монгол Улсад Хятадын эдийн засгийн хамаарал улам бүр өсөх хандлагатай болж, хараат байдалд орох вий гэсэн бүр эртний болгоомжлолыг орчин үед дахин бий болгосон нь эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц сөрөг үзэгдэл болоод байна. Эдийн засгийн хараат байдал нь улс төрийн хараат байдалд оруулах үндэс болдог. Манай улсын хувьд эдийн засгийн аюулгүй байдал нь гадаад хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байж, их гүрнүүдийн түүхий эдийн хавсарга болж ирснийг үгүйсгэхийн аргагүй. Манай улс эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүдийн нэгэнд бусад улс орны түүхий эдийн хавсарга болох; стратегийн ач холбогдол

бүхий экспортын барааны үнэ унах, зах зээл үгүй болох; эдийн засгийн стратегийн ач холбогдол бүхий салбарт улсаас шууд хараат болох асуудлыг хөндөж тавьсан байдаг.

Монголд ажиллаж буй Хятадын томоохон компани, жижиг аж ахуйн нэгжүүд, үйлдвэрүүд нь Монгол Улсын хууль дүрэмд захирагддаггүй, татвар төлдөггүй, монгол ажилчдынхаа цалинг тогтмол төлдөггүй, хөдөлмөр хамгааллын дүрэм журам зөрчдөг, ариун цэврийн наад захын шаардлага хангадаггүй, хууль бусаар орж ирсэн хятад ажилчид дураар авирлахаас гадна хүн наймаалах, хар тамхи, мансууруулах бодис зөөвөрлөх, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгт холбогдож буй мэдээ сэлт хэвлэл мэдээллээр байнга гарах боллоо. Нөгөө талаас манай ард иргэд хятадуудын гар хөл болж хүн худалдаалах наймаанд хамсаатан болох, мансууруулах бодис зөөвөрлөх зэрэг аймшигт хэрэгт татагдан орж эхлэв. Энэ бүхэн нь монголын нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж, хятадын хөрөнгө оруулалтаас болгоомжлох, хятадын эсрэг, “хятадын аюул”-ын үзлийг дэвэргэх, хоёр орны хооронд албан шугамаар үйл ажиллагаа явуулж буй Хятадын нэр хүндийг унагахад хүрч байна.

Өнөөгийн мэдээллийн эриний хөгжлийн үед зэвсэгт хүчний аюулгүй байдалд тулгуурласан уламжлалт ойлголт нь улс төр, цэрэг, эдийн засаг, соёл, мэдээллийн аюулгүй байдлыг агуулсан цогц шинэлэг ойлголт болон хувирч, дэлхийн улс орон бүрт мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах шаардлага тулгараад байна. Мэдээллийн хэмжээ огцом өсч, нийгмийн бүх хүнд хүрдэг болсон нь мэдээллийн аюулгүй байдлын асуудалтай шууд холбогдох болов. Энэхүү мэдээллийн аюулгүй байдал гэж Интернэт мэдээллийн аюулгүй байдлыг хэлж байна. 1990 оноос хойш Интернэт хурдацтай хөгжиж, дэлхий нийтээр хэрэглэх болсон нь мэдээллийн аюулгүй байдлыг шинэ шатанд гаргалаа. Дэлхий нийтийг холбосон компьютерийн сүлжээ интернэт нь дэлхийн өнцөг булан бүрт хүрч цахилгаан холбооны элдэв үйлчилгээг гүйцэтгэхийн зэрэгцээ интернэтийн хэт нээлттэй, чөлөөтэй байдал нь хянаж удирдахад улам төвөгтэй болгожээ. Олон улсын холбогдох байгууллагаас 2007 оны сүүлчээр гаргасан статистикийн мэдээгээр, дэлхийн интернэт хэрэглэгчдийн тоо 1.3 тэрбумаас давжээ. Тухайлбал: 2006 оны сүүлчийн мэдээгээр Хятадын интернэт хэрэглэгчид 137 саяд хүрчээ.⁹ Гэвч БНХАУ-д интернетээр цацдаг гадаадын мэдээллийн хуудас руу ороход хязгаартай, харьцангуй хяналтын дор явагддаг атал Хятадын интернетийн мэдээллийн хуудсуудад Монголын эсрэг, Монгол нь Хятадын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн гэсэн утга агуулга бүхий мэдээллүүд гарах, түүнтэй холбогдсон санал асуулгыг явуулж буй явдал сүүлийн арваад жил тогтмол байгааг хэрхэн үзэх вэ? Харин ч эсрэгээр нь хятадын эрдэмтэд Монгол Улсын интернетийн сүлжээнд хязгаар, хяналт тавих боломж бий юу, түүгээр Хятадын эсрэг чиглэсэн элдэв материал нийтлэгдэж байна гэсэн асуудлыг эрдэм шинжилгээний хуралд удаа дараа тавьж байв. Монгол Улсад сүүлийн жилүүдэд цахилгаан холбоо гар утас, интернет үйлчилгээ, мэдээллийн технологийн дэвшилд хүрч, маш хурдацтай хөгжиж урд өмнө байгаагүй

түвшинд гарч хэн хүссэн нь интернетийг бүрэн ашиглаж, сонирхсон дурын мэдээллийг чөлөөтэй олж авдаг болжээ. Энэ нь тухайн хэрэглэгчийн хэрэгцээг хангаж байгаа боловч түүнийг дагалдсан сөрөг үзэгдлүүд гарсаар байна. Ялангуяа бага насны хүүхэд компьютерээр цаг хязгааргүй тоглож ядаргаанд орох, мэдээллийг боловсруулах чадвар, ухамсар дутуу, төлөвшөөгүй өсвөр үеийнхэн, залуус буруу ташаа мэдээллийг олж үзэх, компьютерийн сүлжээг хүний наймаа гэх мэтэд ашиглах тохиолдол гарах боллоо.

Манай улсад ардчилал хөгжснөөр хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөтэй болж, хэвлэл мэдээлэл үүн дотроо шар хэвлэлүүд олноороо хэвлэгдэн гарч, бие биеэс өрсөн шуугиан дэгдээх, борлуулалтаа нэмэгдүүлэх зорилгоор улсын нууцтай холбоотой байж болох элдэв мэдээ сэлт, тоо баримтыг холбогдох газруудаас ил, далдаар авч, хяналтгүйгээр хэвлэн нийтэлдэг нь улсын үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх талтай. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд мэдээллийн аюулгүй байдлын асуудлаар, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон мэдээллийн бусад эх сурвалжууд үндэсний аюулгүй байдлын талаар шалгагдсан мэдээ, мэдээллийг түгээх замаар аюулгүй байдлын мэдээллийн орчинг бүрдүүлэх тухай тодорхой заасан билээ. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын мэдээллийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлийн нэгд “аливаа улс Монгол Улсын дотоод хэрэгт оролцох” гэж заасан бөгөөд улмаар хөрш орнуудаас Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол, нэн ялангуяа үндэсний язгуур сонирхлын талаар баримталж буй бодлогыг зохих ёсоор харгалзан тусгаж байх, Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хөндөөгүй хөрш хоёр орны маргаанд эс оролцож төвийг сахих бодлого баримтлах тухай заасан.

БНХАУ-ын тухайд, өнөөдөр улсын эдийн засгийн үсрэнгүй хөгжил, түүний нөлөө, хүчин чадал, улс төр, эдийн засаг, цэрэг, арми, соёл, шинжлэх ухааны бүхий л салбарт эрчимтэй нэмэгдэж, нэр хүнд нь өсч байгаатай холбогдуулан хаа сайгүй тархах болсон “Хятадын аюул” гэсэн ойлголт, түүний эерэг, сөрөг нөхцөл байдал дэлхий нийтийн сонирхлыг ихээхэн татаж, цаашид хэрхэхийг олон улсын эрдэмтэн, судлагчид анхааран ажиглаж, өөр өөрсдийн прогноз таамаг дэвшүүлэх боллоо. Ялангуяа 2000 оноос хойш Хятадад гарсан “SARS”, “Шувууны ханиад”, “Гар, хөл, амны өвчин”, “Сүүнийн меламина”-ий асуудал, “Хүүхдийн тоглоомын будаг”, Хятадын дотоодын бизнес бүлэглэлүүдийн хоорондын өрсөлдөөн, хятадын ажилгүйчүүдийн шилжих хөдөлгөөн зэрэг нь дэлхий нийтийг түүн дотор монголын ард иргэдийг Хятадаас болгоомжлох явдлыг ихээр нэмэгдүүлж, “хятадын аюул”-ын үзлийг улам дэвэргэх болсон юм. Ер нь “Хятадын аюулын үзэл”-ийг XIX зууны сүүлч XX зууны эхээр буй болсон “Шарын аюулын үзэл”-ээс үүдэлтэй хэмээн үздэг байна.

Хятадын үндэсний уламжлалт аюулгүй байдлын бодлогын асуудлаар ОХУ-д хэвлэгдсэн “Китай в мировой политике”. МГИМО. Москва РОСЕПЭН. 2001” номонд судалгааны өргөн материал ашиглан хятадын улс төрчид, эрдэмтдийн үзэл баримтлалыг тодорхойлон бичсэн байна.

Тухайн асуудлаар Хятадын улс төр судлаачид, “Хятад улс нь хүйтэн дайны үед эсрэг талын хүчирхэг байдал улсын аюулгүй байдалд заналхийлэх гол үүсвэр нь болж байна гэсэн хүйтэн дайны сэтгэлгээтэй байсан бөгөөд эсрэг талын төрийн байгууллын ялгаанаас болж заналхийлэл улам өсөн нэмэгдэж байсан. Иймээс улсынхаа аюулгүй байдлыг хамгаалах үндсэн нөхцөл нь дайсагнагч улсынхаа зэвсэгт хүчинд шахалт өгөх явдал байлаа. Улсынхаа аюулгүй байдлыг сахин хамгаалах хоёр арга замыг хэрэглэж байсан нь зэр зэвсгээ нэмэгдүүлж, цэргийн хүчин чадлаа өсгөх, нөгөө нь эсрэг талынхаа хүчийг сулруулах явдал байв” гэж бичжээ.

Хятадын эрдэмтэн, улс төр судлагч Янь Сюэтуң: “хүйтэн дайны дараа Хятад улс шинэ нөхцөл байдалд зохицуулан “хүйтэн дайны” үеийн сэтгэлгээгээ хэдийнээ үгүй болгож, олон туйлт үеийн урт хугацааны аюулгүй байдлын тухай цоо шинэ ерөнхий ойлголтыг тодорхойлсон. Олон улсын аюулгүй байдлын заналхийлэл нь улсын бүлэглэлүүдийн хоорондын улс төрийн харилцаагаар тодорхойлогдохоос бус, хүчин чадлын харьцаанаас үл хамаарч буйгаараа ялгаатай болж байна. Магадгүй аль нэг улсаас аюул заналхийлвэл чухам ямар бодлого явуулж буйг нь тодорхойлохоос биш түүний хүчин чадал хэр вэ гэдгийг үл тодорхойлох болно” гэж онцлон тэмдэглэжээ.

Хятадын шинэ үзэл баримтлалаар бол олон туйлт бодлого хэрэгжүүлэх явцад үндэсний аюулгүй байдалд заналхийлвэл хүчин чадал үл хамаарах ба харин энэ үйл явцын харилцаанд явуулж байгаа улс төрийн бодлогыг чухалчлан үзэх болжээ. Одоогоор хоёр төрлийн бодлого олон улсын энх тайван, аюулгүй байдалд заналхийлж болох талтай. Энэ нь нэгдүгээрт, цэргийн хүчээр жанжлалыг олж авахын төлөө улс төрийн тэмцэл, хоёрдугаарт, улс өөрийнхөө жанжлалыг хамгаалахын тулд бусдын цэргийн хүчийг өдөөж шахалт үзүүлэх бодлого байж болно. Үүний эхнийх нь магадлал багатай, харин хоёр дахь нь байж болох талтай, өөрийн жанжлалыг цэргийн хүчээр хамгаалах аюул бодит зүйл¹⁰ юм гэж Хятадын улс төр судлагч Янь Сюэтуң үзжээ.

Хүйтэн дайны дараа, олон улсын шинэ нөхцөл байдал, улс орнуудын эдийн засгийн хөгжлийн шаардлагаар аюулгүй байдлын үзэл баримтлалын тухайд бас шинэ хэллэг, шинэ үзэл баримтлал гарчээ. Ингээд аливаа улс гүрэн бүс нутгийн дотоод гадаад аюулгүй байдлын асуудлыг нягт шүтэлцээ холбоонд авч үзсэн “Comperensive Security” (“нэгдмэл аюулгүй байдал”) болон “Cooperative Security” (“хамтын аюулгүй байдал”) гэсэн ойлголтыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч үндэсний аюулгүй байдалдаа үндсэн баримжааг баримтлах болов. Ялангуяа “comprehensive security” гэсэн шинэ үзэл баримтлалыг хүйтэн дайны дараа Хятадын судлагчид, олон улсын харилцааны эрдэмтэд ихээхэн хэрэглэдэг болсон нь хятадуудын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал хөгжиж өөрчлөгдөж байгаагийн шинж¹¹ хэмээн тодорхойлсон байна. Хятадад “эдийн засгийн аюулгүй байдал” “Guojia Jingji anquan” (“national economic security”) гэсэн нэр томъёо анх 1978 оноос өөрчлөлт шинэчлэл явуулж эхэлсэн үеэс хятад хэлний үгсийн санд орсон¹² хэмээн үздэг байна.

Орчин үеийн олон улсын шинэ дэг журмын дагуу нэг улсын доторхи хүний аюулгүй байдалтай холбоотой эдийн засгийн аюулгүй байдал, эрчим хүчний аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, байгаль орчны аюулгүй байдлаас гадна дээр дурьдсан “нийтийн аюулгүй байдал”, “дэлхийн аюулгүй байдал”, “хүн төрөлхтөний аюулгүй байдал”, “нэгдмэл аюулгүй байдал” гм. шинэ нэр томъёо үүсч, үүнийг уламжлалт бус аюулгүй байдлын хүрээнд авч үзэх болсон. Түүнчлэн уламжлалт бус аюулгүй байдлын хүрээнд хоршооллын аюулгүй байдал, зам тээврийн аюулгүй байдал, санхүү, бизнесийн аюулгүй байдал, нийтийн ахуйн аюулгүй байдал, орон сууцны аюулгүй байдал, шашны аюулгүй байдал, мансууруулах бодис, бэлгийн замын аюулгүй байдал, байгалийн гамшиг, онцгой байдлын аюулгүй байдал, компьютер мэдээллийн аюулгүй байдал зэрэг нь хүн төрөлхтөний анхаарлыг татаж, сонор сэрэмжийг шалгах болжээ.

90-ээд оны эхээр Монгол Улсад ардчилал үүсч, үндэсний үзэл сэргэж эхэлсэнтэй холбогдуулан Хятад нь хойд хилээр Гадаад Монголын үндэсний үзлийн нөлөө Өвөр Монголд орж ирэхээс ихэд болгоомжлон сэрэмжлүүлж байсан¹³ тухай тухайлбал “XXI зууны Хятад улсын стратегийн их төлөвлөгөө. Олон улсын аюулгүй байдлын стратеги” (Beijing 1996) номонд бичиж байсан. Тэгвэл 21 дүгээр зуун гарсаар БНХАУ-ын үндэстний цөөнхийн гол цөм болсон ӨМӨЗО, СУӨЗО, ТӨЗО-нд Баруун бүсийг хөгжүүлэх төслийн хүрээнд томоохон бүтээн байгуулалт хийж, хөрөнгө оруулалтыг маш ихээр нэмэгдүүлэхийн хирээр хятадууд /хань үндэстэн/ маш олноороо шилжин суурьших болжээ. Иймээс БНХАУ нь СУӨЗО, ТӨЗО зэрэг өөртөө засах орнуудад хятадыг эсэргүүцсэн жагсаал цуглаан, үймээн удаа дараа гарсаар байгаа ба түүнийг нь хятадын цэргийн хүчээр нухчин дарж, жагсагчдаас амь үрэгдсэн хүний талаархи мэдээллийг нуун дарагдуулж, тоог цөөрүүлж мэдээлж байгаа нь гадаадын хэвлэлд гарсан тоо баримтаас ихэд зөрүүтэй байна. Үүний сацуу тэдгээр бүс нутагт хятадын цэрэг армийн хүчийг маш ихээр нэмэгдүүлэн зузаатгасаар байгаа юм. Үүнээс улбаалан БНХАУ-ын үндэстний цөөнхийн асуудал, тэдгээр бүс нутгийн аюулгүй байдал нь өнөөдөр БНХАУ-ын дотоодын аюулгүй байдлын чухал хэсэг болоод байна. Уг нь БНХАУ-ын төр, засгийн газраас үндэстний цөөнхийн талаар маш их хөнгөлөлттэй бодлого явуулж хууль тогтоомж батлан гаргадаг. Гэвч түүнийг нь зарим талаар сөргөөр ашиглах явдал гардаг ажээ. Тухайлбал: БНХАУ-ын үндэстний цөөнхийн бүс нутагт оршин сууж буй хятад иргэд нь үндэстний цөөнхийн ард түмэнд хөнгөлөлт үзүүлдэг төрийн бодлого, боломжийг ашиглан тухайн орны үндэстний цөөнхийн нэрээр иргэний үнэмлэх авах явдал мэр сэр гардаг байна. Цөөнх үндэстэнтэй гэрлэсэн хань (хятад) үндэстний үр хүүхэд эцэг эхийнхээ хэнийг дагаж, аль үндэстэн болох сонголтоо өөрсдөө хийдэг байна. Сүүлийн үед БНХАУ-ын дотоодын иргэний үнэмлэх /паспорт/ дээр бичигддэг яс үндэс гэсэн зүйл ангийг бүр хасч, зөвхөн БНХАУ-ын иргэн хэмээн бичих болж буй тухай, улмаар хятад иргэд хаа дуртай газраа шилжин, оршин суух бичиг баримт авч болох талаар яригдаж байна гэсэн албан бус мэдээлэл гадны хэвлэлүүдэд гарч, үндэстний цөөнхийг уусгах хятадын уламжлалт бодлого

үргэлжилсээр байгаа тухай бичсээр байна. Хэрэв Өвөр Монголд оршин сууж буй монгол үндэстний тоо ийм аргаар өсөн нэмэгдвэл тухайн үндэстний хүн амын тоо механикаар өсөхийн зэрэгцээ уг үндэстний цөөнхийн хүн амын тоо буурах таагүй байдал үүсэхээс гадна Монгол Улсын хүн амын тооноос давахаас гадна манай улсад ч сөргөөр нөлөөлөх магадлалтай.

БНХАУ-ын баруун бүсийн нутгийг хөгжүүлэх төсөл, үндэстний бодлогын хүрээнд ӨМӨЗО-ы эдийн засгийн бүтээн байгуулалт, байгаль экологийг нөхөн сэргээх үйл ажиллагаанд маш их хөрөнгө оруулж, ялангуяа аялал жуулчлалын чиглэлээр монгол үндэстний уламжлалыг хадгалсан бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэн, улмаар монгол үндэстний зан заншил, өв уламжлалыг идэвхтэй хөгжүүлж, монгол үндэстний биет бус соёлын өвийг ЮНЕСКО-д идэвхтэй бүртгүүлэх болов. Энэ бүхэн гадаадын аялагч, жуулчдыг ихээр татахын сацуу монгол үндэстэн, монгол ахуй, монгол зан заншил уламжлалыг зөвхөн Өвөр Монголоор хязгаарлах бодлого явуулж байгаа тухай манай албаны хүмүүс, сэтгүүлчид, сурвалжлагчид сонин хэвлэлээр бичиж, радио телевизээр ярьж байсныг дурьдахад илүүц биз ээ. Ер нь манай улсын хил орчмын бүс нутгийн аюулгүй байдал, хилийн боомт газруудын бүтээн байгуулалтын асуудал, тэнд үйлчилж буй хууль тогтоомж, тэдгээрийн үйл ажиллагааг төр засгийн хэмжээнд анхаарах цаг нэгэнт болжээ. ХКН-ын ХҮП их хурлаар Хятад улс нь хөрш орнуудын хувьд бид найрамдал, түншлэлийн харилцааны бодлогоо үргэлжлүүлж, сайн хөршийн харилцаа, бодит хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлнэ. Бүс нутгийн аюулгүй, тогтвортой орчныг хамтран байгуулахын төлөө бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлнэ. Өөрийн бололцооны хэрээр хөгжиж буй орнуудыг тусалж дэмжинэ, хөгжиж буй орнуудын нийтлэг эрх ашиг, хууль зүйн шаардлагыг хангахын төлөө ажиллана гэсэн байна.

Улс хоорондын итгэлцэл, ойлголцлыг гүнзгийрүүлэх үйл хэрэгт соёлын хамтын ажиллагаа ихээхэн эерэг эрч хүч, улам хүмүүнлэг, илүү бүлээн дулаан уур амьсгалыг бүрэлдүүлэх чухал хүчин зүйл болж, томоохон үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 8 дугаар зүйлд Монгол соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах арга замын нэгдүгээрт, нүүдлийн соёл иргэншлийнхээ язгуур шинжүүдийг бататган баяжуулж, дэлгэрүүлэх идэвхтэй бодлого боловсруулан хэрэгжүүлэх тухай заасан байдаг. Үүнтэй холбогдуулан Монгол Улс хөрш орнуудынхаа бүс нутгийн хил орчмын монгол үндэстэн-угсаатанд монгол үндэстний соёлын өв уламжлалаа сэргээн хөгжүүлэхэд нь туслах, зааж сургах, нэг үндэстнийхээ давуу талаа ашиглах, урлаг соёлын хамтарсан бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд борлуулах талаар ихээхэн үүрэг гүйцэтгэж, идэвхтэй ажиллаж ирсэн билээ. Үүний үндсэн дээр Монгол, Хятад хоёр улс хамтран монгол үндэстний соёлын өв болсон морин хуур, монгол ардын уртын дууг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрүүлж, ЮНЕСКО-гийн “Дэлхийн биет бус соёлын өвийн төрөл”-д 2003, 2005 онд тус тус бүртгүүлсэн юм. Ийнхүү дэлхийн түүх, соёлын өв санд үнэтэй

хувь нэмэр оруулсан монгол үндэстэн, нүүдэлчдийн соёл иргэншлэлийг дэлхий нийтэд таниулах анхны алхам боллоо гэж үздэг. Гэвч үүнийг монгол үндэстний соёл иргэншлийн өлгий болсон тусгаар тогтносон Монгол Улсад дангаараа бие даан бүртгүүлэх боломж байгаагүй гэж үү? Басхүү саяхан 2009 онд ЮНЕСКО-гийн “Дэлхийн биет бус соёлын өвийн төрөл”-д монголчуудын хөөмийн урлагийг БНХАУ дангаараа өөрийн нэрээр бүртгүүлээ хэмээн дээр доргүй шуугиж, халаглаж, шүүн хэлэлцэх болов. Энэ нь нэг талаас Монгол Улсын соёл иргэншлийн аюулгүй байдлын хүрээнд түүх, соёлын үнэт зүйлсээ хууль бусаар гадаадад гаргах, алдагдах болсны үр дагавар, холбогдох байгууллагын хариуцлагагүй үйл ажиллагааны уршиг гэхээс өөр яалтай. Нөгөө талаас, бид БНХАУ-д монгол үндэстэн аж төрж, соёлын өв уламжлалаа хадгалан авч яваа ёс заншлаа дээдлэгч тээгчид байдаг гэдгийг умартан, буруу зөрүү ойлголттой ярьж бичиж байгаа нь хоёр улсын соёлын харилцаанд сэв суулгаж, жирийн ард иргэдийн хооронд яс хаясан хэрэг болж, хилийн чанад дахь монголчуудаа цааш түлхэхээс хэтрэхгүй ээ.

Монгол Улс, БНХАУ-ын харилцаа, хамтын ажиллагаа өргөжихийн хирээр манай улсад хятад хэлний хэрэгцээ өсч, хятад хэлний бага дунд сургууль байгуулагдаж, улсын болон хувийн их дээд сургуульд хятад хэлний анги танхим, дугуйлан курс нээгдэж, суралцагсдын тоо нэмэгдсээр “Хятад хэлний олимпиад”-ыг зохион байгуулах хэмжээнд хүрчээ. Үүнээс гадна манай монголчууд хувиараа БНХАУ-ын их дээд сургуулиудад олноороо суралцахын зэрэгцээ эцэг эхчүүд монгол хэлээ бүрэн эзэмшээгүй балчир хүүхдүүдийг хятад хэл сургах зорилгоор Хятадад бага сургуульд явуулж дотуур байранд суулгах болжээ. Үүний үр дагавар хэзээ, яаж гарахыг хэн ч таашгүй.

Монгол Улстай сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэх явдал нь Хятад улсын аюулгүй байдал, гадаад бодлогын нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг. БНХАУ, Монгол Улс 2003 онд харилцан итгэсэн түншийн харилцааг бэхжүүлснээр улс төрийн итгэлцэл нэмэгдэж, эдийн засаг хурдацтай хөгжин бүхий 1 салбарын хамтын ажиллагаа эрчимжиж, тухайн бүс нутгийн энх тайвнаар хөгжих үйлст багагүй хувь нэмэр оруулсан. Хятад-Монголын сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэх нь Хятадын засгийн газрын стратегийн тогтвортой чиглэл хэмээдэг авч хоёр улсын ард түмний хооронд улс төр, эдийн засгийн хөгжлөөс гадна үл ойлголцол оршсоор байгаа тухайн хятадын хэвлэлд бичсээр байна. Одоогоор БНХАУ-ын аюулгүй байдалд Монгол Улсын зүгээс шууд 3 зүйл нөлөөлдөг хэмээн үзжээ. Хятадын Олон улс судлал, стратегийн судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын үзэж буйгаар Монгол-АНУ-ын цэргийн харилцаа, Монгол-Тайваний харилцаа, Далай ламын асуудал юм. Канадын эрдэмтэн Роберт Е.Бедеский өөрийн өгүүлэлдээ “Монголын тусгаар тогтнол дахь аюул заналхийлэл бол Хятад улс мөн” хэмээн бичсэн байна. Түүний бичсэнчлэн БНХАУ нь Монгол Улсыг дэлхийн том гүрнүүдээс аль болох тусгаар байлгах сонирхолтой байдгаас гадна гурав дахь хөршийн асуудалд эмзэглэн ханддаг байдал илт ажиглагддаг гэжээ. Хятадын талаас Монгол Улсад

АНУ-ын нөлөөлөл геополитикийн асуудал, ЗХА-д цэргийн хяналтаа тогтоох, улмаар НАТО-д оруулахаас болгоомжлох, Монголд оруулж буй Японы хөрөнгө оруулалт, зээл буцалтгүй тусламж нь Ази, Номхон Далайн бүсэд Хятадыг хязгаарлахаас сэрэмжлэх, Монголын уул уурхай, ашигт малтмалын төлөө орон зайг эзлэх их гүрнүүдийн өрсөлдөөн гэх мэтийн асуудлыг гадаадын хэвлэлүүдэд бичсээр ирсэн нь нууц бишээ. Далай ламын тухайд, түүнийг Монгол Улсад айлчлах тоолонд БНХАУ дургүйцлээ ямар нэг хэмжээгээр илэрхийлж тухай бүр манай засгийн газар энэ бол цэвэр шашны асуудал хэмээн тайлбарлах шаардлага гардаг. 2002 онд Далай ламыг айлчлахад Монгол-Хятадыг холбосон төмөр замыг “техник”-ийн гэх шалтгаанаар хаасан.¹⁴ 2006 онд Далай ламыг Монголд айлчлах үеэр урьд өмнө тохирсон байсан дээд хэмжээний айлчлалаа хойшлуулсан байна. Далай ламтай холбоотой айлчлалыг Монгол-Хятадын харилцаанд учирч болзошгүй асуудлын нэг “risk factor” хэмээн үзсэн явдал ч гарчээ¹⁵ хэмээн Стратегийн судалгааны хүрээлэнгийн шинжээч О.Машбат эш болгон бичсэн байна. Уг нь Далай ламын асуудал зөвхөн тусгаар тогтносон Монгол Улс, шашны асуудал эрхэлсэн сүм хийд, түүнд сүжиглэгч ард түмний асуудал баймаар. Монгол Улсын Үндсэн хуульд “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” хэмээн зааж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын нийгэм-төрийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлд “төрийн байгууллага, шашны сүм хийд төрийн хэрэгт үл оролцох зарчим алдагдах” гэсэн тодорхой заалт бий. Монгол Улс Тайванийг Хятадын нэг хэсэг гэдэгт баттай зогсож, төр, засгийн хэмжээнд бус олон нийтийн байгууллага, хувь хүмүүсийн хоорондын эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн чиглэлээр харилцаа, хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна. Гагцхүү БНХАУ нь ХКН-ын ХҮП их хурлаар гадаад бодлогынхоо стратегийн чиглэлүүдийг тодорхойлохдоо: ...Бүх улс орнуудын ард иргэд өөрсдийн хөгжлийн замаа сонгох эрхийг хүндэтгэх бөгөөд бусад орны дотоод хэрэгт хэзээ ч хөндлөнгөөс оролцохгүй, өөрсдийн хүслийг хүчээр тулгахгүй. Бид олон улсын маргаан, халуун цэгүүдийн асуудлыг энх тайвны аргаар шийдвэрлэхийн төлөө ажиллах бөгөөд олон улс, бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүх хэлбэрийн терроризмийн эсрэг байна. Хятад улс өөрийгөө хамгаалахад чиглэсэн үндэсний батлан хамгаалах бодлого хэрэгжүүлнэ, зэвсэглэлээр хөөцөлдөхгүй, аливаа нэг улсад цэргийн заналхийлэхгүй. Хятад улс бүх хэлбэрийн жанжлах үзэл, хүчний бодлогын эсрэг байна, эзлэн түрэмгийлэх үйл ажиллагаа хэзээ ч явуулахгүй”¹⁶ гэсэн байр сууриндаа баттай зогсох хэрэгтэй.

2003 онд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Вэн Зябао АНУ-ын Харвардын Их сургуульд илтгэл тавихдаа: “Өчигдрийн Хятад нь эртний гялалзсан соёл иргэншилтэй их гүрэн байсан бол өнөөдрийн Хятад улс өөрчлөлт шинэчлэл, гадаадад нээлттэй байх бодлогыг хэрэгжүүлж, энх тайвныг дээдэлж буй их гүрэн мөн, харин маргаашийн Хятад улс бол энх тайвныг эрхэмлэгч бүрэн найдвартай их гүрэн болно” гэж онцлон

тэмдэглэжээ. Мөн 2005 оны 4 дүгээр сард Жакарта хотноо болсон Ази-Африкийн дээд хэмжээний уулзалтанд БНХАУ-ын дарга Ху Жиньтао “Эв зохистой дэлхийг хамтаар байгуулах”¹⁷ гэсэн санааг дэвшүүлжээ. Ийнхүү Хятад улс дэлхийд тархсан “хятадын аюул” гэсэн ойлголтыг намжаах зорилгоор “энх тайвнаар хөгжих” гэсэн санааг гарган албан ёсоор зарлаж, гадаад бодлогынхоо ерөнхий зарчим болгожээ. Улмаар ХКН-ын ХҮШ их хурлаар “Хятад улс дэлхийгээс тусгаарлагдан ганцаар хөгжиж чадахгүй, дэлхий дахин ч хятадгүйгээр хөгжил цэцэглэлт, тогтвортой байдалд хүрэх боломжгүй. Хүн төрөлхтөний сайн сайхан ирээдүйн төлөө хятадын ард түмэн цаашид ч бусад улс орны ард иргэдтэй хамтран ажиллах болно” хэмээн ХКН зарлан тунхагласан нь дэлхий нийтийн анхаарлыг татсан юм. Аливаа улсын үндэсний аюулгүй байдал нь олон улсын байдал, түүний хөгжил, хандлага, бүс нутаг, хөрш зэргэлдээ орнуудын дотоод, гадаад байдал тэдгээрийн хоорондын харилцаа зэрэг олон хүчин зүйлээс шууд хамааралтай байдгийн тодорхой жишээг уг тунхаг харуулж байна.

Нөгөөтэйгүүр 2008 оны 8 дугаар сарын 8-нд 08 цагаас Бээжингийн Олимпийн их наадмын нээлтийг сүр дуулиантай эхлүүлж, Хятад улс нь сүүлийн 30 жилийн бүтээн байгуулалтын амжилт, эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан техникийн үсрэнгүй хөгжил, инновацийн дэвшлийг дэлхий нийтэд харуулахын зэрэгцээ хятадын ард түмнийг өөрийн түүх уламжлал, эдийн засгийн хөгжил, удирдагчдынхаа зөв мэргэн бодлого явуулж буйгаар бахархах сэтгэлийг төрүүлж улмаар даян дэлхийн ард түмний эв санааны нэгдлийг бэхжүүлснээр дэлхийд тархсан “хятадын аюул”-ыг түр боловч намжаах оролдлого хийсэн юм. Энэхүү Бээжингийн Олимпийн наадмаас Монгол Улсын тамирчид ч 3 алт, 2 мөнгөн медаль авснаар монголчууд дээр доргүй баярлаж, Бээжингийн Олимпийн наадам монголчуудад ээлтэй байсныг бахархан ярьцгааж байсан билээ. Харин 2009 оны 10 дугаар сарын 1-нд БНХАУ байгуулагдсны 60 жилийн ойн баярын ёслолын үйл ажиллагаагаар Хятадын цэрэг зэвсгийн сүр хүчийг гайхуулсан нь дэлхийн улс орнуудын анхаарлыг ихэд татаж, Хятадаас болгоомжлох аюулыг нэмэгдүүлээ хэмээн гадны хэвлэлд бичжээ.

2009 онд дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн санхүүгийн хямралаас улбаалан улс орон бүр бие биеэс хамааралтай болсноор түүнд зэрэг өртөх аюул нөмөрч, улмаар алт, зэсийн үнэ, манай зах зээлд голдуу эргэлддэг валютин (доллар, юань) ханш нэмэгдэж, юмны үнэ, бараа таваарийн үнэ өртөг нэмэгдснээр хаа сайгүй бухимдлыг бий болгож, хямралыг үндэсний аюулгүй байдалд хохирол багатай хэрхэн гэтлэн давах арга замыг улс орон бүр өөрийн онцлогт тохируулан эрэлхийлж байв. Манай улсын хувьд санхүүгийн хямралыг далимдуулан угаас буруу явж ирсэн бодлого, санхүүгийн гаж тогтолцоог засч залруулах, төсөв, мөнгө, зээлийн бодлогыг зохистой хэрэгжүүлэх боломж нээгдэж, гадаадын хөрөнгө оруулалтыг оновчтой ашиглах, гадаадын хөрөнгө оруулалтаар үндэсний жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх таатай нөхцөл бүрдэж байгааг ухаалгаар зөв шийдвэрлэх хэрэгтэй болсон юм. Харин БНХАУ нь дэлхийн

санхүүгийн хямралд үл цочирдон, улс орноо хөгжүүлэн цэцэглүүлж, хөрөнгө оруулалт зээл тусламжийг олгосоор байлаа.

Сүүлийн үед Хятадын талаас Монголын улс төрийн тогтворгүй байдал, иргэдийн хөдөлгөөний элдэв эсэргүүцлийн жагсаал цуглаан, “Даяар Монгол” хөдөлгөөнийхний явуулдаг зарим нэг үйл ажиллагаа зэргээс ихээхэн болгоомжилдог тухай хятадын эрдэмтэн судлаачид ярих болов. Манай улс үндэснийхээ аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг эх сурвалжаар нь гадаад дотоод хэмээн ангилж, Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох хүчин зүйлийг тодорхойлсон байдаг боловч ер нь манай монголчуудын аливаа асуудлыг сэтгэлийн хөөрлөөр шийддэг байдал, дээрээсээ доод шатанд хүртэл автагдсан авлига, хээл хахуулийн асуудлаас болж, бусад улс оронтой хийсэн гэрээ хэлцлийн үйл ажиллагааг зогсоох, эргэж буцах байдал элбэг тохиолдлогоос гадаадын хамтран ажиллагсад, хөрөнгө оруулагчдын итгэлийг эвдэх, тууштай шударгаар хамтран ажиллах нөхцөл байдалд эргэлзээ төрүүлдэг.

Эцэст нь хэдийгээр манай хоёр орны ард түмний дунд зарим нэг үл ойлгоцол, үл итгэлцэл байдаг ч бид хөршийнхөө эдийн засгийн үсрэнгүй хөгжлийг бахархан сайшааж, хятадын ард түмний хөдөлмөрч ажилсаг чанарыг бахдан хүндэлсээр ирсэн билээ. БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн хаялга ч манай улсын эдийн засгийн хөгжилд ихээхэн тус дэм болж буйг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Иймээс Монгол Улс, БНХАУ-ын харилцааны хөгжлийн стратегийн шинэ орчин, дараагийн жарны хамтын ажиллагаа, үндэсний уламжлалт аюулгүй байдлын бодлогод шууд нөлөөлж болзошгүй уламжлалт бус аюулгүй байдлын хүчин зүйлийг оновчтой, зөв зүйтэй тодорхойлон гаргаж, улс орон, нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж болох үл ойлголцол, үл итгэлцэлийг хоёр талын хүчин чармайлтаар даван туулах, түүнээс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой хэмээн үзэж байна.

Хүн төрөлхтөний оршин тогтнох газар нутгийн бохирдол, байгалийн гамшиг, байгалийн элдэв үзэгдэл, дэлхийг хамарсан цаг уурын дулаарал, цөлжилт, халдварт өвчний тархалт, ядуурал, цагаачлал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг түүн дотор хүн худалдаалах, мансууруулах бодис зөөх, химийн бодис, цөмийн түүхий эд дамжуулан худалдаалах оролдлого хийх, олон улсын терроризм гэх мэт уламжлалт бус аюулын хүрээ улам өргөжиж, шинэ шинэ аюул заналхийлэхийн хэрээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа эргэн сөхөж, нягтлан судалж, уг үзэл баримтлалдаа өөрчлөлт оруулах шаардлага урган гарсаар байна. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үндсэн асуудал нь өдгөө гадны аюул халдлагаас өөрийгөө хамгаалахаас илүүтэй улс үндэстнийнхээ аюулгүй оршин тогтнох дотоод, гадаад таатай нөхцлийг бий болгоход оршиж байна.

Иймд Монгол Улс үндэснийхээ аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг гадаадаас эрэхээс өмнө нэн тэргүүнд улс үндэстний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй дотоодод хуримтлагдсан авлига хээл хахууль, бизнес бүлэглэлүүдийн өрсөлдөөн, ядуурал, архидалт,

ажилгүйдэл, гэр бүл салалт, нийтийг хамарсан халдварт элдэв өвчин гэх мэтээс ангижран салахад төр засаг, хувь хүмүүс дор бүрнээ хичээж, эрүүл чийрэг, эрхэлсэн ажилдаа эзэн болж, эх орноо хөгжлийн шинэ шатанд гаргах цаг хэдийнээ болжээ.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Стратеги судлал” сэтгүүл. №34 (2/2006), №35 (3/2006)
2. “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”. “Дорно-Өрнө” сэтгүүл 1994, №2 т.5
3. John Edelman Spero. The Politics of International Economic Relations. 1995.р. 105
4. “Проблемы Дальнего Востока” 6/2008 стр.75
5. “Проблемы Дальнего Востока” 6/2008 стр.76
6. “Өнөөдөр” сонины 2007 оны 5 дугаар сарын 7
7. “Өнөөдөр” сонин. 2007.05.15, №113/3071/”
8. Б.Ганзориг, Д.Начин. Монгол Улс дахь Орос, Хятадын хөрөнгө оруулалтын тухай. “Олон улс судлал”, 2006, №3 т.7
9. “International strategic studies” сэтгүүл 2007.3
10. “Китай в мировой политике”. МГИМО. Москва РОСЕПЭН. 2001
11. “Хятадын хөрш орнуудын аюулгүй байдлын орчинд дүн шинжилгээ хийх нь”. (中国周边环境分析). Beijing 2003
12. Liu Jianping, “Guojia Jingji Anquan Wenti Yanjiu Shuyao [Summary of research on national economic security] Remnim Ribao, January 1999, p.6)
13. “XXI зууны Хятад улсын стратегийн их төлөвлөгөө. Олон улсын аюулгүй байдлын стратеги” (21世界中国战略大策划. 国际安全战略). Beijing 1996
14. Tsedendamba Batbayar. “Mongolia’s Foreign Policy in the 1990’s; New Identity and New Challenges” Regional Security Issues and Mongolia, 2002.148
15. “Стратеги судлал”, №42 (2/2008)т.83
16. Ван Хао. “Ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлж, эргэлзээг тайлах “Хятадын аюул үзэл” Монголд оршиж буйн учир шалтгааныг тандах нь” илтгэл. 2009. (增信释疑- 浅析“中国威胁论“在蒙古国存在的原因)
17. ХКН-ын ХҮИ их хурлын материал